



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Эрүүл мэндийн даатгалын үндэсний
зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлах тухай**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14¹ дүгээр зүйлийн 14^{1.4} дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн хавсралтаар баталсугай.


2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд олгох урамшууллын хэмжээг эрх бүхий байгууллагаас тогтоосон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сар бүр тооцож, улирал тутам олгож байхаар тогтоосугай.

3. Энэ дүрмийг мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга (Т.Мөнхсайхан)-д даалгасугай.

4. Энэ тогтоол баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай” 27 (14) дугаар тогтоол, “Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл (орон тооны бус)-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай” 2018 оны 06 дугаар 29-ний өдрийн 18 дугаар тогтоол, “Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН



Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын
байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 22
ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн даатгалын бодлого, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн удирдлага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, өртгийг тогтоох, чанарын хяналтыг хэрэгжүүлэх зохицуулалтыг хангах, эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажиллах зарчим, бүрэн эрх, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлоход оршино.

1.2.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь /цаашид "Үндэсний зөвлөл" гэх/ эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих дээд байгууллага мөн.

1.3.Үндэсний зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, даатгагч, даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэгш оролцоог хангах, албан үүргээ ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй тохиолдолд татгалзах, ёс зүйтэй, шударга, хариуцлагатай гүйцэтгэх, асуудлыг хамтын удирдлагаар хэлэлцэх, олонхын саналаар шийдвэр гаргах, хараат бус, нээлттэй, ил тод байх зарчмыг баримтална.

1.4.Үндэсний зөвлөлөөс баталсан тогтоол, журам, дүрэм, зөвлөмж, удирдамжийг эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талууд хэрэгжүүлнэ.

1.5.Үндэсний зөвлөл тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, цахим хуудас хэрэглэнэ.

Хоёр.Үндэсний зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

2.1.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг танхимаар, эсхүл цахимаар зохион байгуулж болно. Хуралдааны дэгийг Үндэсний зөвлөл тогтооно.

2.2.Үндэсний зөвлөл нь гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр улиралд хоёроос доошгүй удаа хуралдах бөгөөд хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга, түүний эзгүйд дэд дарга удирдана.

2.3.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26.1.5-д заасан гамшгийн онцгой нөхцөл байдал зарласан тохиолдолд Үндэсний зөвлөлийн хуралдааныг цахимаар хийж болно.

2.4.Үндэсний зөвлөлийн хуралдаанаар Үндэсний зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын буюу гуравны хоёроос дээш саналаар шийдвэрлэнэ.

2.5.Үндэсний зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаантай бол хэлэлцэх асуудалд өөрийн санал, шийдвэрийг дэмжих эсэхийг хуралдаан болохоос ажлын нэг өдрийн өмнө ажлын албанд санал, хүсэлтээ ирүүлсэн тохиолдолд хуралдаанд оролцсонд тооцно.

2.6.Шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөлийн дарга болон гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно. Ээлжит бус хуралдааны зарыг ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө гишүүд болон оролцогч талуудад мэдэгдэнэ.

2.7.Энэ дүрмийн 2.1-д заасан хуралдааны дэгийн дагуу Үндэсний зөвлөлийн хуралдааныг иргэн, даатгуулагч, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой олон нийтэд цахимаар нээлттэй зохион байгуулна.

2.8.Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан баримт бичгийн төсөл, эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжид холбогдох төрийн захиргааны төв байгууллага, бусад байгууллагаас санал авахаар заасан бол саналыг Үндэсний зөвлөлийн ажлын албанд хуралдаан болохоос ажлын 5 өдрийн өмнө ирүүлнэ.

2.9.Ажлын алба нь Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг хүлээн авч, баримт бичгийн бүрдүүлбэрийг хянан хуралдааны тов, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох баримт бичгийг хуралдаан зохион байгуулахаас ажлын 5 өдрийн өмнө Үндэсний зөвлөлийн гишүүдэд хүргүүлж, холбогдох байгууллагад мэдээлнэ.

2.10.Үндэсний зөвлөл нь хэлэлцэж буй асуудлаар зөвлөгөө, мэдээлэл, тайлбар, тодруулга авах зорилгоор хуралдаанд Техникийн хорооны гишүүн болон мэргэшсэн шинжээч, судлаач, мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.

2.11.Үндэсний зөвлөлийн шийдвэрийг тогтоол хэлбэрээр гаргаж, Үндэсний зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурж, тогтоолд тамга дарснаар баталгаажна.

2.12.Үндэсний зөвлөлийн хуралдааны шийдвэр олон нийтэд нээлтэй, ил тод байх бөгөөд уг шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр мэдээлнэ.

2.13.Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг ажлын алба хариуцан хөтөлж, Үндэсний зөвлөлийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

2.14.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн сарын урамшууллын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоож, улирал тутам олгоно.

Гурав.Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг

3.1.Үндэсний зөвлөл Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараах эрх эдэлнэ:

3.1.1.Эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.2.Даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээний талаар эрүүл мэндийн даатгалын байгууллагаас боловсруулсан тооцоо, судалгаа, саналыг хянаж, дүгнэлт гаргах;

3.1.3.Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, холбогдох албан тушаалтан, даатгуулагчаас Үндэсний зөвлөлийн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээлэл, судалгааг гаргуулан авах, мэдээллийн нууцыг хадгалах;

3.1.4.Техникийн хорооны дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, жагсаалт, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар шийдвэр, санал, дүгнэлт гаргах;

3.1.5.Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлагад хяналт шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох хяналт шалгалтын байгууллага, Аудитын байгууллагыг оролцуулах;

3.1.6.Эрүүл мэндийн даатгалын байгууллагын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтоож, уг шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэлийг улирал бүр үнэлж, хариуцлага тооцох, холбогдох арга хэмжээ авах;

3.1.7.Улсын Их Хурал, холбогдох Байнгын хорооноос гаргасан тогтоол, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3.2.Үндэсний зөвлөл дараах үүргийг гүйцэтгэнэ:

3.2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг эрүүл мэндийн даатгалын байгууллагаас хийсэн актуар тооцоололд үндэслэн сангийн төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

3.2.2.Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг хянаж, үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.2.3.Иргэд, ажил олгогч, даатгуулагч, төрийн болон төрийн бус байгууллагаас эрүүл мэндийн даатгалын асуудлаар эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай тайлан, мэдээллийг жилд нэг удаа хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээ авах;

3.2.4. Үндэсний зөвлөлийн ажлын албаны дүрмийг батлах;
3.2.5. Үндэсний зөвлөлийн шийдвэр гаргахдаа эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд Засгийн газар, ажил олгогч, даатгуулагч, иргэд, олон нийтийн байгууллагын идэвхтэй, тэгш оролцоог хангах;

3.2.6. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Дөрөв. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийн эрх, үүрэг

4.1. Үндэсний зөвлөлийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, үйл ажиллагааны гүйцэтгэлийн жилийн тайланг хамтран хэлэлцсэний үндсэн дээр үнэлэлт дүгнэлт өгч, Улсын Их Хуралд жил бүр тайлагнах;

4.1.2. Үндэсний зөвлөлийн хуралдааны тов болон хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлах;

4.1.3. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн талаар болон бусад холбогдох асуудлаар Үндэсний зөвлөлийн гишүүдтэй санал солилцох, хэлэлцэх, хамтран шийдвэр гаргах;

4.1.4. Төрийн болон олон нийтийн албан ёсны үйл ажиллагаа, гадаад хамтын ажиллагаанд Үндэсний зөвлөлийг төлөөлөн оролцох.

4.2. Үндэсний зөвлөлийн гишүүд дараах эрх, үүрэгтэй:

4.2.1. Үндэсний зөвлөлийн хуралдаанд тухай бүр оролцож, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн саналыг оруулах;

4.2.2. Үндэсний зөвлөлийн дүрэм, хуралдааны дэгийг мөрдөх;

4.2.3. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдаанд хэлэлцүүлэх асуудлаар саналаа нээлттэй, ил тод илэрхийлэх;

4.2.4. Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр урьдчилан мэдэгдэх;

4.2.5. Үндэсний зөвлөлийн хуралдаанд эрүүл мэндийн даатгалтай холбогдох асуудлаар санал тавьж хэлэлцүүлэх;

4.2.6. Үндэсний зөвлөлөөс томилсон ажлын хэсэгт ажиллах, ажлын гүйцэтгэлийг тайлагнах;

4.2.7. Шийдвэр гаргахад шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээлэл, судалгааг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, мэдээллийн нууцыг хадгалах;

4.2.8.Үндэсний зөвлөлийн хуралдаан, шийдвэрийн талаар иргэд, даатгуулагчдад нээлттэй мэдээлэл өгөх, зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах;

4.2.9.Үндэсний зөвлөлийн зорилго, зорилтод үл нийцэх үйл ажиллагаанд оролцох, амлалт өгөхийг хориглох;

4.2.10.Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Тав.Үндэсний зөвлөлийн ажлын алба

5.1.Ажлын алба нь эрүүл мэндийн даатгалын асуудлаар шийдвэр гаргахад мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, гишүүдийг мэдээллээр хангах, Үндэсний зөвлөлөөс баталсан дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

5.2.Ажлын албаны даргыг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Үндэсний зөвлөлийн дарга томилж, чөлөөлнө.

5.3.Ажлын албаны ажилтнуудыг ажлын албаны дарга Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу томилж, чөлөөлнө.

5.4.Ажлын албаны дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог Үндэсний зөвлөл батална.

5.5.Ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарах бөгөөд цалингийн сүлжээ, албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэвийг Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын ажлын албатай дүйцүүлэн тогтооно.

5.6.Ажлын алба нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан Үндэсний зөвлөлийн гишүүний урамшуулал болон ажлын албаны үйл ажиллагааны зардлын төсөвтэй байх бөгөөд төсвийг ажлын албаны дарга захиран зарцуулна.

Зургаа.Хариуцлага

6.1.Энэ дүрмийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---